

Орон бүхний пролетариат нар нэгдэвчтэй!

АНХ ДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

26 дахь жилдээ

№ 30 (2294)

1974 оны 4 дүгээр сарын 17

ЛХАГВА

ШАГНАЛ АВАВ

Бүх ард түмний социалист уралдааны жил-1973 онд аймгийн соёл, ардын боловсрол, эрүүлйг хамгаалах байгууллагуудын хооронд зарласан социалист уралдааны дүнг саяхан гаргав. Уралдаанд авсан амлалт үүргээ үзүүлэлт бүрээр 101,4—139,1 хувиар биелүүлсэн соёлын байгууллагуудыг I байр эзлүүлэн аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөлийн уралдаанд шилжин явах туг, 2000 төгрөгөөр, уралдааны амлалт үүргээ үзүүлэлт бүрээр нь 102,8—109,2 хувиар биелүүлсэн эрүүлйг хамгаалах байгууллагыг II байр эзлүүлэн аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөлийн диплом, 1500 төгрөгөөр тус тус шагнав.

Я.ДАМДИНСҮРЭН

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САР ЭХЭЛЛЭЭ

Агаар ус, амьтан, ургамлын аймаг, газар шороо цөм хүнийг хүрээлэн буй орчин юм. Манай ард түмэн эрт дээр үеэс хүрээлэн байгаа байгаль орчноо цэвэр ариун байлгахын төлөө ямагт санаа тавьж ирсэн сайхан заншилтай билээ.

Нам, засгаас сүүлийн жилүүдэд байгаль орчныг хамгаалах олон чухал арга хэмжээ авч байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн VI чуулганы шийдвэр ёсоор 4 дүгээр сарын 15-наас 5 дугаар сарын 15 хүртэл байгаль хамгаалах дөрөв дэх сарын ажлыг эхэлж байна.

Байгаль хамгаалах нь байгалийн баялаг түүний тэнцвэрийг алдагдуулахгүй шинжлэх ухааны үндэстэй зөв ашиглахыг хэлнэ. Өнгөрсөн жилүүдэд байгаль хамгаалах сарын ажлаар байгаль хамгаалахын ач холбогдлыг хөдөлмөрдөд төрөл бүрийн хэлбэрээр сурталчлах, зарим ховордож байгаа амьтанд хамгаалалтын бүс тогтоох, гал түймрийн өдөрлөг зохиох, байнгын сахиул, хамгаалалттай болгох, хот, сууриныг тохижуулах ажил зохиосон нь үр дүнгээ өгсөн юм.

Гэвч зарим байгууллага, байгаль хамгаалах сарын ажлыг далайц үр нөлөө муутай явуулах, байгалийн баялгийг зөв зохистой байр гэмтэй ашиглах, ой, агнуурын хууль дүмнийг биелүүлэхэд анхааралгүй хандаж байна.

Энэ I улиралд аймгийн ангийн нийгэмлэг, ойн аж ахуйгаас явуулсан шалгалтаас үзэхэд Баянзүрх, Баяндэлгэр, Мөнгөнморьт сумын нутаг, Туул, Хэрлэн голд зөвшөөрөлгүй, хугацаа зөрчиж загас барих, Туул голын сав ногоон бүсэнд их хэмжээгээр бургас огтлох түвшинд хэрэглэх зөрчил илэрчээ.

Алтанбулаг сумын 8 жилийн дунд сургууль зөвшөөрөлгүй 1,5 га талбайн бургасыг хавтгайруулан огтолсны гадна Мөнгөнморьт сумын хорих ангийн ажилтан Энхээ ан агнуурын хууль зөрчиж дархан цаазтай буга агнасан байв.

Байгалийн нөөц баялгийн нэг хэсэг ой, агнуурын баялгийг хамгаалж зөв ашиглах нь байгууллага, хамт олон, иргэн бүрийн хойшлуулшгүй зорилт мөн. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1964 оны тогтоолоор манай орны бүх ойг ардын аж ахуйн ач холбогдлоор нь гурван бүс болгон хуваасан юм.

Нэгдүгээр бүсэд хот, суурын газрын орчны хамгаалалт, хүн амын эрүүл ахуйн шаардлагыг хангах зорилгоор тогтоосон ногоон зурвас бүсэд хамгаалалтын чанартай хэсгийн ой хамаарагдана.

Ийм ойд үйлдвэрийн чанартай ашиглалт явуулахгүй, гагцхүү түүний байгалийн гоо үзэмжит байдал, ашигтай чанар хэв төрхийг хэвээр байлгах зорилгоор арчлан хамгаалах огтлолт хийнэ.

Мод бэлтгэлийн газрууд байгалийн үзэсгэлэнт байдлыг эвдэхгүйн тулд мод бэлтгэлийн талбайг хуваарилж ойн зохион байгуулалт, ойн хууль дүмийн заалтыг нарийн баримтлах нь чухал.

Байгаль хамгаалах сарын ажлаар иргэн бүрийн байгаль орчинтой харьцах харилцааг сайжруулахад чиглэгдсэн ухуулга таниулыг төрөл бүрийн хэлбэрээр далайцтай явуулах ялангуяа залуу үеийнхэнд энэ талаар гүн бат мэдлэг олгох ажил зохиох, ой агнуурын хуулийг зөрчих явдалтай тэмцэх, зөрчлийг илрүүлж арга хэмжээ авах, хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулан, энэ ажилд анхдын нийгэмлэгийн бригадын зөвлөд идэвхтэн гишүүдийн оролцоог сайжруулах нь чухал байна.

Нутаг дэвсгэрийнхээ амьтдын байршилтыг судалсны үндсэн дээр ховордож байгаа үнэт амьтдыг байршуулах, зарим газар шилжүүлэн нутагшуулж тогтнох боломжоор хангах ажлыг зохиох хэрэгтэй.

Юуны урьд ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг далайцтай зохиох ёстой. Байгалийн баялгийг хамгаалж зохистой ашиглах нь нийгмийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах чухал эх булаг болдгийг санаж ажилла.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн ЗАРЛИГ

Танхайрагчид, нийгмийн хэв журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай

Танхайрагчид, нийгмийн хэв журам зөрчигчдөд хариуцлага өгөх тухай тэмцлийн хүчтэй болгох талаар иргэд, олон нийтийн байгууллагаас гаргасан санал хүсэлтийг харгалзан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГА

1. Олон нийтийн газар хэрүүл маргаан үүсгэх, бусдыг өдөөн хоргоох, айлан сүрдүүлэх, цээрлэх үүгээр хараах, үйлчилгээний газрын журмыг гажуудуулах, дараалын журам зөрчих, байр орон сууцанд бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, барилга байгууламж, гудамж талбай, зүлэг модыг гэмтээх, бохирдуулах зэргээр нийгмийн хэв журмыг санаатайгаар зөрчиж, жижгээр танхайрсан этгээдийг арваас гуч хоног хүртэл хугацаагаар баривчлах буюу гурван зуун төгрөг хүртэл торгохо.

2. Энэ зөрчилд арга хэмжээ авахуулах тухай нийгмийн хэв журам зөрч-

хүсэлтийг зөрчил гарснаас хойш 14 хоногийн дотор гаргаж болно.

Зөрчлийн тухай материалыг цагдан сэргийлэх байгууллага хүлээн авч 48 цагийн дотор шалгаж зөрчил гаргасан этгээдийг энэ зарлигийн 1 дүгээр зүйлд заасан хэмжээгээр торгох буюу холбогдох материалтай нь шүүгчид шилжүүлнэ.

Шүүгч материал хүлээн авснаас хойш 48 цагийн дотор шаардлагатай бол нотлох баримт нэмэн бүрдүүлж, зөрчил гаргасан этгээдийг байгууллагын түүнд энэ зарлигийн 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээний аль нэгийг тогтоол гарган оногдуулна. Хэрэв шаардлагатай гэж үзвэл гэм буруутай этгээдийг шүүгч, цагдан сэргийлэх байгууллага шийдвэр гарах хүртэл албадан саатуулж болно.

Цагдан сэргийлэх байгууллага, шүүгч байхгүй газар нийхүү нийгмийн хэв журам зөрчсөн тухай материал гомдлыг сум, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаа хүлээн авч, нийгмийн хэв журам зөрч-

сөн баримтыг 3 хоногийн дотор бүрдүүлэн, энэ зарлигийн 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээний аль нэгийг захирамж гарган оногдуулна.

3. Нийгмийн хэв журам зөрчигчдөд хүлээлгэх захиргааны арга хэмжээг 16 буюу түүнээс дээш насны хүмүүст хэрэглэнэ. Энэ зарлигийн 1 дүгээр зүйлд заасан зөрчлийг 16 хүртэл насны хүүхэд үйлдвэл тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагчдад олон нийтийн арга хэмжээ авахуулах буюу цагдан сэргийлэх байгууллагын тогтоол, цагдан сэргийлэх байгууллага байхгүй газарт сум, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргааны захирамжаар энэ зарлигийн 1 дүгээр зүйлд заасан хэмжээгээр торгоно.

4. Нийгмийн хэв журам зөрчигчдөд захиргааны арга хэмжээ авсан тухай цагдан сэргийлэх байгууллага буюу шүүгчийн тогтоол, сум, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргааны захирамжаар энэ зарлигийн 1 дүгээр зүйлд заасан хэмжээгээр торгоно.

(Төгсгөл нь II нүүрт)

Төл бойжилтын явц

Аймгийн хэмжээгээр 4 дүгээр сарын 12-ны байдлаар төлөвлөх зохих эх малын 62,8 хувь буюу 399,0 мянга нь төлөж гарсан төлийн 99,3 хувь нь буюу 399,7 мянга нь бойжиж байна.

Төл бойжилтыг сумдаар байр эзлүүлбэл:

Сумдын нэрс	Бойжилтын хувь	Эзлэх байр
Баянцагаан	100,0	1
Угтаал	99,9	2
Эрдэнэсант	99,9	3
Алтанбулаг	99,8	4
Баян-өнжүүл	99,8	5
Баян	99,8	6
Баянцогт	99,8	7
Дэлгэрхаан	99,7	8
Өндөрширээт	99,7	9
Баянжаргалан	99,7	10
Лүн	99,7	11
Сэргэлэн	99,5	12
Баянзүрх	99,5	13
Баянчандмань	99,5	14
Борнуур	99,4	15
Мөнгөнморьт	99,2	16
Батсүмбэр	99,1	17
Эрдэнэ	98,6	18
Бүрэн	98,5	19
Баяндэлгэр	97,6	20
Заамар	96,8	21
Жаргалант	96,5	22

Статистикийн товчоо

ТЭМЭЭЧНИЙ СУУРИЙНХАН

Бүрэн сумын «Бүрэн-дэлгэрэх» нэгдлийн Дашням ахлагчтай тэмээний суурийн энэ жил ботголвол зохих ээлжийн 25 нэгнээс 22 нь ботгож ботго нь бүрэн аж.

Эднийх ботыг гардан бойжуулж, улж номхруулан, ботголох нигнүүдийг сувай тэмээнээс ялган ойрын бэлчээрт харнуулж байна.

Арван хоёр жил тэмээ маллаж тэмээний арчилгаа маллагааг сайн мэдэх болсон тэмээчин Дашням 35 ингийг гардангаар бүрэн хээл авахуулан 60 гаруй эмнэг тэмээг уналга эдэлгээнд сургаж тэмээчдийн улсын зөвлөгөөнийг угтан бүх тэмээндээ зүсмийн данс хөтөж тамгалан, тэмээнүүдийг эр ноосыг авч бүрэн тушааж дуусгаад энэ жил 10 эмнэг ингийг саалинд оруулж сургахаар ажиллаж байна.

Ш.ГАНТӨМӨР

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн ЗАРЛИГ

Танхайрагчид, нийгмийн хэв журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай

Төгсгөл. (Түрүүч нь I нүүрт)

5. Цагдан сэргийлэх байгууллага шүүгч, сум, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаа нь нийгмийн хэв журам зөрчсөн этгээдийн зан төрх, үйлдлийн шинж байдлыг харгалзан, олон нийтийн арга хэмжээ авахуулахаар материалыг холбогдох олон нийтийн байгууллага буюу олон нийтийн шүүхэд шилжүүлж болно.

Уг материалыг хүлээн авсан байгууллага ямар арга хэмжээ авсан тухайгаа 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.

6. Цагдан сэргийлэх байгууллага баривчлагдсан этгээдийг тусгай байранд байлган, биеийн хүчний ажил хийлгэж, хөдөлмөрийн хөдсийг улсын орлогод оруулна.

Орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа тэднийг ажлаар хангах үүрэгтэй.

Шаардлагатай гэж үзвэл баривчлагдсан этгээдийг хязгаарлагдмал хангамжтай байлгаж болно.

Баривчлагдсан этгээд өөрийн буруугаар биеийн хүчний хөдөлмөр хийгээгүй бол мөн хугацаанд түүнээс хоног тутам 25 төгрөг гаргуулан авна.

7. Баривчлагдсан этгээд уг арга хэмжээнээс зайлсхийсэн буюу баривчлах байрны дотоод журмыг ноцтойгоор зөрчвөл баривчлах байрны захиргаа буюу цагдан сэргийлэх байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шүүгч буюу сум, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаа баривчлах хугацааг 15 хоног хүртэл сунгаж болно.

Харин баривчлах нийт хугацаа 45 хоногоос хэтрэх болохгүй.

8. Цагдан сэргийлэх байгууллага, шүүгч, сум, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаа арга хэмжээ авсан тухайгаа зөрчил гаргасан этгээдийн ажиллаж, сурч, оршин суугч байгаа газрын захиргаа буюу олон нийтийн байгууллагад заавал мэдэгдэнэ.

9. Гэмт үйлдлийг таслан зогсоох буюу буруутай этгээдийг саатуулан баривчлахын тулд иргэдээ явуулсан үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу байвал буруутай этгээдэд хохирол учруулсан ч хариуцлага хүлээлгэхгүй.

II. ТАНХАЙРАГЧДАД ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

10. БНМАУ-ын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийг өөрчилж, дор дурдсанаар найруулсугай:

«169 дүгээр зүйл. Танхайрах

а) олон нийтийг илтэд хүндэтгэн үзэхгүй, нийгмийн хэв журам, хамтын аж байдлын социалист хэв журмыг санаатайгаар зөрчсөн, эсвэл нийгмийн хэв журам зөрчсөн хэрэгт захиргааны арга хэмжээ авагдсан этгээд нэг жилийн дотор дахин тийм хэрэг гаргасан байвал хоёр жил хүртэл хугацааг хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван зуугаас нэг мянган төгрөг хүртэл торгоно.

б) энэ зүйлийн «а»-д заасан гэмт хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэсэн буюу онц жигшүүртэй догшин авирласан, эсхүл нийгмийн хэв журам сахиулах үүргээ гүйцэтгэж байгаа хүмүүс буюу танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэдийг эсэргүүцсэн, түүнчилэн танхайрсан хэргийг давтан буюу бүлгэлж үйлдсэн бол уг нутгаас зайлуулах буюу зайлуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

в) энэ зүйлийн «а», «б»-д заасан гэмт хэрэг үйлдэхдээ галт зэвсэг, хутга, мээ, түүнчилэн хүний бие махбодид гэмтэл учруулахаар тусгайлан бэлтгэсэн зүйлийг хэрэглэсэн буюу хэрэглэхээр завдсан, танхайрсан хэрэгт удаа дараа шийтгэгдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг уруу татаж танхайрсан хэрэгт оруулсан бол нутаг зааж суулгах буюу суулгахгүйгээр гурваас арван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

11. БНМАУ-ын эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйлд дор дурдсан нэмэлт өөрчлөлт оруулсугай:

«41 дүгээр зүйлийн «б»-д дээрх хийсэн (168 дугаар зүйл) гэсний дараа «хүндрүүлэх шалтгаантайгаар танхайрсан (169 дүгээр зүйлийн «б», «в»), мөн зүйлийн «г»-д «дээрх хийсэн (168 дугаар зүйл) гэсний дараа «хүндрүүлэх шалтгаантайгаар танхайрсан (169 дүгээр зүйлийн «б») гэснийг хасах».

III. БНМАУ-ЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

12. БНМАУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хуульд дор дурдсан агуулгатай VIII хэсэг нэмсүгэй:

VIII хэсэг

ТАНХАЙРСАН ХЭРГИЙН ТАЛААР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

Гучин зургадугаар бүлэг

Танхайрсан хэргийн талаар гүйцэтгэх ажиллагаа

404 дүгээр зүйл. Танхайрсан хэргийн талаар гүйцэтгэх ажиллагааны журам

Танхайрсан хэргийн талаар гүйцэтгэх байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан ерөнхий журмаас гадна энэ бүлэгт дурдсан журмыг баримтална.

405 дугаар зүйл. Шүүхэд материал шилжүүлэх тухай

БНМАУ-ын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн «а»-д заасан гэмт хэргийн талаар цагдан сэргийлэх, хэрэг бүртгэх бусад байгууллага долоо хоногийн дотор ямар хэргийг хэн үйлдсэн болохыг тогтоож гэм буруутай этгээд, хохирогч, гэрчийн тодорхойлолт гаргуулах ба холбогдож байгаа этгээд урьд захиргааны арга хэмжээ авагдсан буюу ял шийтгүүлж байсан эсэх тухай баримт түүнчилэн ажлын газар буюу сургуулиас ажил байдлын тодорхойлолт зэрэг хэргийг шүүхэд хэлэлцэхэд ач холбогдол бүхий материалыг бүрдүүлнэ.

Гэмт этгээдийн үйлдсэн хэрэг, хувийн байдлыг харуулсан протокол үйлдэж, түүнд холбогдох бүх материал, шүүхэд дуудан ирүүлбэл зохих хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хавсаргана.

Протоколыг хэрэг бүртгэх байгууллагын дарга баталж, бүх материалыг холбогдогч этгээдэд танилцуулан, энэ тухай протоколд зохих тэмдэглэл хийж, прокурорын зөвшөөрөлгүйгээр шүүхэд шилжүүлнэ.

406 дугаар зүйл. Хэрэг бүртгэх ажиллагаа

БНМАУ-ын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн «а»-д заасан гэмт хэргийн талаар зөвхөн дор дурдсан тохиолдолд хэрэг бүртгэх ажиллагаа явуулна:

а) гэмт хэргийг нотлоход чухал ач холбогдол бүхий байдлыг энэ хуулийн 405 дугаар зүйлд заасан хугацаанд тогтоож чадаагүй бол.

б) шүүх хурлаас тогтоох боломжгүй бөгөөд гэмт хэргийг нотлоход чухал ач холбогдол бүхий байдлыг тодруулахаар шүүх материалыг буцаасан бол.

Хэрэг бүртгэх ажиллагааг эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу материал шүүхээс буцаж ирсэн өдрөөс эхлэн 20 хоногийн дотор дуусгаж, ял төлөвлөх буюу хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Хэрэг бүртгэлт явуулахдаа энэ хуулиар мөрдөн байцаалт явуулахаар тогтоосон журмуудыг баримтлахаас гадна хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч нарт хэрэг бүртгэлтийн ажиллагаа дууссан тухай мэдэгдэх ба харин хэргийн материалыг танилцуулахгүй.

Энэ хуулийн 127 дугаар зүйлийн 2 дугаар хэсгийн заалт хэрэг бүртгэх байгууллагад хамаарахгүй.

Хэрэг бүртгэх байгууллага прокурорын заалтыг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт гомдол гаргах боловч өгсөн заалтыг биелүүлэх явдлаас чөлөөлөгдөхгүй.

407 дугаар зүйл. Урьдчилсан мөрдөн байцаалт явуулах хугацаа

БНМАУ-ын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн «б», «в»-д заасан гэмт хэргийн талаар явуулах урьдчилсан мөрдөн байцаалтын ажиллагааг эрүүгийн хэрэг үүсгэсэн өдрөөс эхлэн нэг сарын дотор дуусгана.

Онцгой тохиолдолд энэ хугацааг зохих шатны прокурор нэг сар хүртэл сунгаж болно.

408 дугаар зүйл. Албадан саатуулах, таслан сэргийлэх арга хэмжээ авах

БНМАУ-ын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулж, хэрэг бүртгэлт, урьдчилсан мөрдөн бай-

цаалт явуулахдаа цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авна.

409 дүгээр зүйл. Шүүх материалыг шийдвэрлэх

БНМАУ-ын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн «а»-д заасан гэмт хэрэг үйлдсэн тухай материалыг шүүх хүлээн авмагц гурав хоногийн дотор дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана.

а) шүүхэд материалыг хэлэлцэхэд хангалттай гэж үзвэл эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхэд шилжүүлэх;

б) эрүүгийн хэрэг үүсгэхийг татгалзах;

в) хэрэг бүртгэлт хийлгэхээр материалыг буцаах.

410 дугаар зүйл. Шүүхэд хэрэг хэлэлцэх

БНМАУ-ын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн «а»-д заасан хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс эхлэн тав хоногийн дотор шийдвэрлэнэ.

Шүүх хурал дээр тогтоох боломжгүй, хэрэгт чухал ач холбогдол бүхий байдлыг тодруулахаар шүүх материалыг хэрэг бүртгэх байгууллагад буцаах эрхтэй.

Хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан танхайн хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс эхлэн долоо хоногийн дотор хэлэлцэнэ.

13. БНМАУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 126 дугаар зүйлийн нэгдэх ангид «162 дугаар зүйлд» гэснийг «162 дугаар зүйл, 169 дүгээр зүйлийн «а»-д гэж» өөрчилсүгэй.

14. Энэ зарлигийн 1-9 дүгээр зүйлүүдийг биелүүлэх тухай заавар гаргахыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд даалгасугай.

15. Энэ зарлигийг 1974 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

16. Энэ зарлиг гарсантай холбогдуулан «Олон нийтийн хэв журам»-ыг танхайрагчдад хариуцлага хүлээлгэж байх тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1961 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 301 дүгээр зарлигийн 9 дүгээр зүйлээс бусдыг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн

нэгдүгээр орлогч дарга

С. ЛУВСАН

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн

нарийн бичгийн дарга

Ц. ГОТОВ

1974 оны гуравдугаар сарын 25. Улаанбаатар хот

МАРКСИЗМ—ЛЕНИНИЗМИЙН СУРГААЛЫГ БҮТЭЭЛЧЭЭР ЭЗЭМШЬЕ

Аймгийн Намын хорооны улс төр тэгээрлийн кабинет, заах аргын зөвлөлөөс эрхлэн намын улс төрийн рүүгийн сонгогчдоо зориулж марксизмын сонгодог рин зохиолуудын талаар бэлтгэсэн материалыг дор нийтлэл.

В.И.Ленин энэ зохиолоо нэгдүгээрт: социалист хувьсгал хийгээд хуучин засгийн оронд ямар засаг төр тогтоох, хэлбэр агуулга нь ямар дэдэг онол практик чухал асуудал хувьсгалчдын өмнө аж байсан үед энэ дэд хариу өгөх, хоёр-арт: төрийн тухай Маркс-сургаалыг гуйвуулан авхруулж, хөрөнгөтний төрийг эвдэж пролетарийн диктатур тогтоохыг эсэргүүцэж, зөвхөн тайван өөрчлөлтөөр пролетари нар улс төрийн эрх чөлөө олж, ардчилсан ёсыг тогтоож болно гэж олон түмнийг хууран мэхлэж байсан оппортунистуудад цохилт өгөх зорилгоор 1917 оны 8, 9 дүгээр сард нууц байдалд (Разливт) бичсэн юм. Уг зохиол нь төрийн тухай Маркс, Энгельсийн сургаалыг хамгаалаад зогсоогүй түүнийг хөгжүүлсэн юм. Зохиолын нэгдүгээр бү-

лэгт төрийн гарал үүсэл, шинж чанар, төрийн мөхлийг тодорхойлжээ.

Төр нь нийгэм ангиудад хуваагдсан түүхэн хөгжлийн тодорхой шатанд үүсчээ.

Хүй нэгдлийн байгуулалын үед эсрэг тэсрэг анги, өмч хөрөнгө гэж байгаагүй учраас төр байсангүй.

Харин хүй нэгдлийн байгуулал задран, өмч хөрөнгө үүсч анхны боол эзэмшигч ангит нийгэм тогтохын хамт боол эзэмшигчдийн төр үүсчээ.

Социалист хувьсгал ялж, хөрөнгөтний төрийн машиныг эвдэж устгасны үр дүнд пролетарийн диктатурын төр тогтдог юм.

Марксизм—Ленинизм на-маар удирдуулсан пролетари-ийн төр нь улам өсөн бэхж-сээр социализмыг бүрэн төгс байгуулж, коммунизм өрнүүн байгуулалтад шилж-сэн үед зөвлөхүүдийн бүгд

найрамдах улс, пролетарийн диктатурын төрийн хэлбэрээс нийт ард түмний төрийн хэлбэрт шилжиж болохыг В.И.Ленин суугаар урьдчилан харсан нь биеллээ олов.

Уг зохиолд; төр бол нийг-мийн хөгжлийн тодорхой нэг шатанд үүссэнтэйгээ адил нийгмийн хөгжлийн тодор-хой шатанд мөхөх тавилан-тай түүхэн үзэгдэл мөн боло-хыг заажээ.

В.И.Ленин, зохиолдоо; про-летарийн диктатурын хэл-бэр, түүний гүйцэтгэх үүр-

«Капитализмаас комму-низмд шилжих шилжилт нь улс төрийн маш олон янзын хэлбэр гаргахгүй байж ча-дахгүй нь мэдээж боловч тэгэхдээ мөн чанар нь зайлш-гүй нэг байх бөгөөд энэ нь пролетарийн диктатур байх болно» гэсэн юм. (25 дугаар боть 430 дахь тал)

Социалист хувьсгалын ялалтын дараа төр хэрэггүй мэт үзэж байсан анархист хандлагуудад эрс цохилт өгөөд зогсоогүй харин со-циалист төрийн үүрэг социа-

байдаг коммунизмын анхны шат юм.

Коммунизм бол үйлдвэр-лэлийн арга ба үйлдвэрлэ-лийн харилцааныхаа мая-гаар өндөр хөгжлийн шат бөгөөд «Хүн бүр чадлын хи-рээр, хүн бүрт хэрэгцээний нь хирээр» гэдэг зарчим биел-лэгдэнэ.

Коммунизмын үед нийг-мийн нэг өмч байх ба хот тосгон ангиудын онц ялгаа арилсан байна гэж дүгнэ-жээ.

Ленин, зохиолынхоо төгс-гөлд социалист хувьсгалаар хөрөнгөтний төрийн маши-ныг устгаад ажилчин, тари-ачин, цэргийн депутатуудын зөвлөлт бүгд найрамдах төр пролетарийн хувьсгалт ди-ктатурыг тогтоохын зайлш-гүйг заажээ.

В.И.Лениний энэ гайхам-шигт бүтээл нь шинэ шинэ улсууд социалист хувьс-гал хийж, өөрийн ноёрхлын засаг төрийг тогтоох, социа-лист орнуудад социализмын бүрэн төгс ялалтыг хангах ба коммунизмыг даян дэл-хийд ялуулахад онол прак-тикийн гандан бууршгүй ач холбогдолтой юм.

М.САМДАН

ТӨР БА ХУВЬСГАЛ

гийг тодорхойлсон байна.

Пролетарийн диктатурын төрийн анхны хэлбэр нь Парисын коммун юм.

Парисын коммун нь хөрөнгөтний төрийн хуучин маши-ныг эвдээд түүнийг ямар төрөөр солих вэ? гэдэгт бодит сургамжийг өгчээ.

Ленин уг зохиолдоо ангиу-дын тэмцлийг пролетарийн диктатурт хүртэл зөвшөөр-дөг тийм хүн л марксист мөн гэж тодорхойлжээ.

лизмын хөгжлийн үе шат бүрт ямар байх тухай марк-сист үндэслэлийг хөгжүүл-сэн юм.

Зохиолын 5 дугаар бүлэгт коммунист нийгмийн хоёр шатны тухай, төр мөхөх эдийн засгийн нөхцлүүдийн тухай тайлбарлажээ.

Социализм бол хөгжсөн коммунизм биш бөгөөд хүн бүр чадлын хирээр хийж хийсний хирээр авах гэдэг социалист зарчим ноёрхож

Хуучин хэвшлийг эвдээд шинэ хэвшил бий болгох ажилд шилжиж байгаа нь

Октябрийн аугаа их хувьс-галын дараа, иргэний интервенцын довтол-он дуусан үе—1920 оны 4 тээр сард В.И.Ленин бич-сэн.

Ленин энэ өгүүлэлдээ со-циалист нийгэм дэх хүмүү-ийн хөдөлмөр түүний мөн нар, өмнөх нийгмийнхээс с ялгаатайг нотлож, нэ-тл өөрийн аз жаргалын тө-лөө бүрэн чөлөөтэй хөдөл-мөрлөх болсон энэ үед хү-мүүс нь ухамсартай сахил-га баттайгаар нийгэм, эх орныхоо төлөө бие хайргүй ажиллахаас эрхэм дээд зор-илгыг байхгүй болохыг заа-сан юм.

Коммунист хөдөлмөр нь ЗХУ-д 1918 онд эхэлсэн бо-ловч эсэргүү бослого, гадаад дотоодын харгис хүчний дов-толгооны улмаас зөвлөлт за-саг энх тайван байгуулал-тын талаар ямар нэг хэм-жээгээр буурь суурьтай шур-гуу ажиллах бололцоогүй байлаа.

Гэвч хувьсгал ялсан 2 жи-лийн дотор социализмын үндсэн дээр бүтээн байгуу-лах ажил хийхэд зарим туршлага олсон юм гэж Ле-нин тэмдэглээд коммунист хөдөлмөрийн тухай асууд-лыг одоо сайн тавьж болох ба нарийвчлан хэлэлцвэл капитализмаас үүсэн гарч байгаа нийгмийн шинэ хэв байдлын хөгжлийн дээд биш доод анхан шатны тухай ярьж байгаа болохоор ком-мунист биш социалист хө-дөлмөрийн тухай тавьж бо-

лох бөгөөд тавих ч ёстой гэжээ.

Ленин коммунист хөдөл-мөрийн агуулга шинж чана-рыг тодорхойлохдоо: «Ком-мунист хөдөлмөрийг жинхэнэ нарийн утгаар нь хэлбэл нийгмийн тусын тулд хийж байгаа хөлсгүй хөдөлмөр, оногдсон үүргийг гүйцэтгэ-хийн тулд ба зохих хэмжээ-ний бүтээгдэхүүн авахын тулд тогтоосон нормоор хийж байгаа биш, харин сайн дураараа нормгүй хийж бай-гаа хөдөлмөр, хөлс шан авах бололгүйгээр хийж байгаа хөдөлмөр, нийгмийн тусын тулд хөдөлмөр зайлшгүй хэрэгтэй гэдгийг ухамсарлан (дадал заншил болж) хийж байгаа хөдөлмөр, эрүүл биенийн хэрэгцээ болох хөдөлмөр юм» гэж заажээ.

Цааш бичихдээ: Манай нийгмийн байгуулал нйм хө-дөлмөрийг жинхэнэ өргөн олноороо хийдэг болох хүр-тэл тун их удах нь плэрхий юм. Гэвч тэргүүний проле-тари нар (коммунист нам, үйлдвэрчний эвлэл, засаг төрөөс) уг асуудлыг тавьсан нь тэр зам руу урагш дав-шиж байгаа алхам юм.

Их юм хийхийн тулд ба-гаас нь эхлэх хэрэгтэй гэ-жээ.

Пролетари нарт засгийн эрхийг шилжүүлсний дараа аж ахуйн амьдралыг шинэ үндсэн дээр байгуулах аж-лыг зөвхөн багаас нь эхэлж болно.

Субботник (хөдөлмөрийн арми) хөдөлмөрийн алба бол социалист, коммунист

хөдөлмөрийг практик дээр олон янзын хэлбэрээр биел-лүүлж байгаа юм гэдгийг зааж, нйм шинэ, нйм бэрх, нйм аугаа их үйл хэрэгт алдаа дутагдал, амжилтгүй явдал зайлшгүй гарна.

Социализмын байгуулал-тын бэрхшээлээс зурхшээж, түүнээс айж, итгэл зориггоо алдан сандарч байгаа хүн бол социалист хүн биш юм гэжээ.

«Хөдөлмөрийн шинэ са-хилга тогтоох, хүмүүсийн хооронд нийгмийн харилцаа-ны шинэ хэлбэрийг бий бол-гох, хүмүүсийн хөдөлмөрт татан оруулах шинэ хэлбэ-рийг олох нь олон арван жи-лийн ажил юм. Энэ бол хам-гийн эрхэм сайн ажил мөн» гэж Ленин заав.

Хөрөнгөтнийг түлхэн уна-гаж, түүний эсэргүүцлийг да-раад нйм ажил хийж болох үндэс суурьтай болсон нь бидний аз жавшаан юм.

Бид энэ ажлыг бүх хүч чадлаараа тэсвэр хатуу жил-тай, шийдэмгий зоригтой хийж юмыг зуу дахин шал-гаж, зуу дахин засч залруу-лах, зорьсон зорилгодоо заа-вал хүрэх чадвартай байх чанарыг пролетари нар Ок-тябрийн хувьсгалын өмнө 10—20 жилийн турш олж ав-сан бөгөөд хувьсгалын да-раа ч үзэгддэггүй гамшиг зов-лон, үгүйрэл хоосролын дун-дуур олж авсан юм.

Энэ нь пролетари нарын ялахын баталгаа мөн гэж заасан байна.

Ленин энэ зохиолдоо про-летари нар засгийн эрхийг аймагч хөрөнгөтний нийг-мийн хуучин хэвшлийг уст-ган шинэ социалист хэвшил бий болгох ажилд шилжин орохын чухлыг зааж комму-нист хөдөлмөр гэж юу болох тухай дэлгэрэнгүй тодорхой-лолт өгчээ.

Социализмын бүтээн бай-гуулах их үйлсэд хөдөлмөрч-дийг өргөн оролцуулах нь бэрхшээлтэй боловч эрхэм сайхан энэ ажлын чухлын тухай Лениний заасан заалт нь шинэ нийгмийг цогцлол байгуулж байгаа өнөөгийн нөхцөлд онол практикийн үлэмж ач холбогдолтой юм.

Ж.ДУЛМАА

ЗӨВЛӨЛТ ЗАСГИЙН ЭЭЛЖИТ ЗОРИЛТ

В.И.Ленин «Зөвлөлт зас-гийн ээлжит зорилтууд» зо-хиолынхоо бичмэл эхийг «Одоо үед Зөвлөлт засгаас тавих зорилтуудын тухай сэдвүүд» нэртэйгээр 1918 оны 3 дугаар сарын 23—28-нд хэлж бичүүлжээ.

В.И.Ленин энэ зохиолдоо; Октябрийн социалист хувьс-галын хөгжилд гүнзгий шин-жилгээ хийж, капитализмаас социализмд шилжих шил-жилтийн үед улс ардын аж ахуйг зөв удирдах, энэ үеийн эдийн засгийн талаар дэв-шүүдсэн зорилтуудын ач холбогдлыг тодорхойлон заажээ.

—Төр үед залуу Зөвлөлт ор-ны гадаад байдал туйлын хүнд, түгшүүртэй байв.

Гадаадын империалистууд тус орныг зөвхөн цэргийн талаар хавчаад зогсохгүй,

орос орныг хувааж авах, Зөвлөлт засгийг устгахаар тохиролцохыг эрмэлзэж байв.

Иймд Зөвлөлт Бүгд Най-рамдах Улс, хэцүү болзол-той, бат бэх биш найрамд-лын гэрээний дүнд бий бол-сон түр амсхийлтыг ашиглан эдийн засгаа түргэн өрнүү-лэх, батлан хамгаалах хү-чин чадлыг зузаатгах, социа-лист армийг байгуулахын тө-лөө бүх хүчээ дайчлах, нөгөө талаар Европын хэд хэдэн оронд бэлтгэгдэж буй про-летарийн хувьсгалыг бүрэн төгс боловсрох хүртэл арга-цаан ухрах, хүлээх такти-кийг гадаад бодлогодоо баримтлахыг чухалчилж бай-лаа.

В.И.Ленин Зөвлөлт бүгд найрамдах улсын дотоод бодлогыг тодорхойлж хэлэх-

дээ: «1918 оны 3 дугаар са-рын 15-нд бүх оросын зөвлө-лүүдийн их хурлаас гаргас-нан тогтоол ёсоор одоо үед зохион байгуулалтын зорилт тулгарч байна.

Машины нийгэмчлэгдсэн том үйлдвэрийн суурь дээр бүтээгдэхүүнийг үйлдвэр-лэх, хуваарилах явдлыг ши-нэ маягаар, дээд зэргээр зо-хиох, чухам энэ зорилт бол Орос оронд 1917 оны 10 ду-гаар сарын 25-ны өдөр эхэл-сэн социалист хувьсгалын гол агуулга, бүрэн төгс ялах гол нөхцөл юм» гэжээ.

—В.И.Ленин Зөвлөлт бүгд найрамдах улсын эдийн зас-гийн зорилтуудыг «... шинэ маягийн зөвлөлт төрийн бий болгосноороо бид хүнд бэрх

(Төгсгөл нь IV нүүрт)

Л. СОДНОМДАРЖАА

БИРИЙН ТӨЛӨӨ

Эрдэнэсант, Дэлгэрхаан, Бүрэн сумын төлөх бөгөөд малчдын хувь нь 80-90 гаруй хувь нь төлөөд, гарсан төл нь 95-99,9 хувьтай байж байна.

Бог малын суурь бүрийг тохилдог хороо цүнз, ус, тэжээл, хангаж төлөө хагас бүрэн хөрвийн аргаар буйжуулж байгаагийн дүнд сумын төл бойжиж өнгөрсөн онд нийт хувь харьцуулж төлийн хорогдол хэмжээгээр багасчээ.

Тийн штабууд сайн ажиллаж сумын хариуцлагатай, МАА-н мэргэжилтнүүд сум малчдаар тогтмол явж ажил байдалтай нь танилцаж, хүн хүчээр тусалж, төл бойжилтын ажил дээр гарсан дутагдлыг богино хугацаанд засах талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч байна.

Нөгөө талаар төл бүрийг хэмжээтэй болгохоос эхлээд ус бэлчээр-тэжээлийн нөөцтэй байх, малыг цөөлж эх ба төл мал нэг бүрийг жигд сайн маллах бололцоогоор хангах, МАА-н мэргэжилтэн, сум-бригадын төлийн штабын хариуцлагатнуудыг төл хорогдож байгаа сууриудад байнга байлгах, нийт төлчдөд хүн, малын эмч, агент, соёл, урлагаар үйлчлэх, ухуулга сурталчилгааг тогтмол хийж, хэвлэлийг шуурхай хүргэж байгаа зэрэг ажлын сайн эхлэлт авуштай арга нилээд байна.

Эдгээр сумын төл бой-

жилтын ажилтай биечлэн танилцаж, бог бодын 20 гаруй суурь орж үзэхэд хойшид анхаарч ойрын үед яаралтай засууштай дутагдал үзэгдэж байлаа.

Одоогийн байдлаар Дэлгэрхаан сумын «Залуучуудын хөгжил» нэгдлийн хэмжээгээр 42, Бүрэн сумын «Бүрэндэлгэр» нэгдэл 522 төл хороогоод байгаагийн гадна 400 шахам ихэртэйгээр, гарсан төлөө бараг 100 хувь буйжуулж байгаа Эр-

раа малчдын ажиллагааг хүндрүүлдгээр барахгүй сүргийн эргэлт өсөлт, үржлийн ажилд муугаар нөлөөлдгийг анхаарч охин төлгийг ялгаж суурилах талаар хойшид анхаарах нь чухал юм. Дэлгэрхаан сумын зарим малчид малын хээл хамгаалах талаар муу анхаарч, хээлтэй мал ба төлийн ус бэлчээр, тэжээлийг тохируулахгүй, арчилгаа маллагаа хангалтгүй байгаагаас болж хоньчин Г. Шараа, С. Цэрэнбат нарын суурьт 170 гаруй хонь, ямаа хээл хаяж, Б. Миеэгийн суурьт 30 гаруй төл хорогджээ. Бүрэн суманд шөвөг ярилээд хэмжээгээр гарсан бөгөөд түүнийг яаралтай зогсоох талаар шуурхай арга хэмжээ аваагүй

ХӨРВӨЖСӨН ТӨЛӨӨ БҮРЭН БОЙЖУУЛЪЯ

дэнэсант сумын «Саруул амьдрал» нэгдэлд ч ганц нэг төлийн хорогдол гарч байна.

Хэдийгээр ус бэлчээр өвс тэжээл хүрэлцээтэй байгаа боловч төл хөрвөжж томрох тутам ус тэжээлээр дутагдаж булаг шанд худал хавийн бэлчээр муудаж болзошгүй байна.

Эрдэнэсант суманд усны машин, ус нөөцлөх 6 канитер ажиллуулж байгаа боловч уг машин «Баян-уул» бригадэд 3-5 хонгоноор очихгүй байгаа дутагдал үзэгдэж байлаа. Түүнчлэн зарим суманд охин төлөг ялгаагүй буюу дутуу ялагснаас болж, төлөг хээл авч, төлөг чадлаагүй бэртэж үхэх, гарсан төл нь «ихрийн» тоонд орж явдаг тал ч ганц нэг суурьт үзэгдэж байв.

Төлөний төл нь жилбэ муутай, бие султай бойжилт удаантай байдгаа-

учир одоогийн байдлаар 522 төл хорогдоод байна.

Үхлийг зогсоох, өвчлэсн төлийг эдгээх талаар тус сумын нам, захиргааны байгууллагаас удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авснаар төлийн хорогдол багасаж байгаа боловч эртнээс зохион байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авсан бол үүнээс цөөн төл хороож болох байжээ.

Нөгөө талаар малчдын хариуцлага сул, арчилгаа маллагаа муугаас болж төл сэнсрэх, хатгалга авах, гэдэс нь өвдөх зэргээр төл хорогдох тал ч үргэлжилсээр л байгаа ажээ.

Түүгээр ч барахгүй, «Будлангаа» бригадын хоньчин С. Бадарч өөрийн хариуцлагагүй залуу хойргоос болж илүү гэрээ хийж хонхосон 107 хургыг бүтээж үхүүлсэн байна.

Эдгээр сумын төл хорогдсон байдлыг шалгаж үзвэл, мал бөөнөөр төлөх үед эх хурга хоёрыг таньж цагт нь хөхүүлэхгүй, төлийг салхи хүйтний огцом цочролд оруулж, хатгалга тусгах, төл бойжуулах шилдэг арга-хөрвөжилтийг шаардлагын дагуу бүрэн хэрэглэхгүй байгаагаас болжээ.

Дээрх сумдын бог малын ихэнх нь төлөж, төл нь хөрвөжж байгаа тул хөрвөжсөн төлийг эхтэй нь хамт бэлчээрт удаан явуулж, турж эцээн сэнсрүүлэхээс болгоомжилж, хөрвөжсөн төлд тавих анхаарлыг эрс сайжруулах нь юу юунаас чухал байна. Е. нь малд төлөх үед бүхний анхаарал төлд чиглэн хүн бүр чармайлт гарган нөр хичээнгүй ажилладаг бөгөөд харин төл хөрвөжж, урин цаг наашлаад ирэхээр санаа авчарч, тайвширч байгаад хөрвөжсөн төлийг их хэмжээгээр хороочихдог муу тал байдгийг анхаарах нь зүйтэй байна.

Хөрвөжсөн төлийг бүрэн мэнд бойжуулахын тулд хүрэлцэхүйц хэмжээний өвс ус, хужир шүү, тохилог дулаан хашаа хороотой байхаас гадна төл нэг бүрт тавих анхаарлыг улам нарийн чанд болгож, зусаг малын төлийг цөөлж хүн хүчээр хангаж, төл хорогдож байгаа ба болзошгүй сууриудад МАА-н мэргэжилтнүүдийг байнга суулгаж ажиллуулмаар байна.

Нэгэнт хөрвөжүүлсэн төлийг сэнсрүүлэхгүй малдуулах талаар социалист уралдаан өрнүүлж ноогоод цагдаа ажлыг нарийн төлөвлөгөөгөөр удирдах тодорхой ажил зохиох хэрэгтэй.

Манай тусгай сурвалжлагч
Б. ТОГООХУЙ

ЗАЛУУЧУУД ХОШУУЧИЛЖ БАЙНА

Аймгийн ХЗЭ-ийн гишүүд залуучууд таван ногоо хураах, хадлан тэжээл бэлтгэх, төл бойжуулах зэрэг цаг үеийн ажлыг даамт хошуучилдаг юм.

Одоо аймгийн хэмжээгээр МХЗЭ-ийн гишүүд нийтдээ бодын 99,6-ийн 250 суурьт 270 гаруй мянган толгой мал төлүүлэхээс 180 гаруй мянган мал төлүүлж гарсан төлийг 99,9 хувиар бойжуулж байгаагийн дотор Алтанбулаг, Баян, Эрдэнэсант, Лун сумын эвлэлийн гишүүдийн хариуцсан төл бойжилт 100 хувьтай байна.

Баянцагаан сумын эвлэлийн гишүүн Г. Лхамсүрэн 533 хониноос 571 хурга, Баян сумын эвлэлийн гишүүн Ц. Сүхбаатар 153 хониноос 156 хурга бойжуулжээ.

Мөн Батсүмбэрийн САА-н ХЗЭ-ийн гишүүд 1347 хониноос 1361 хурга бойжуулж байгаагийн дотор МХЗЭ-ийн гишүүн илгээлтийн эзэн Д. Энхтуяа 404 хониноос 404 хурга, Л. Мэндбаяр 455 хониноос 458 хурга, Б. Түмэнбаяр 490 хониноос 501 хурга тустуу хорогдолгүй бойжуулж хамт олноо хошуучилж явна.

Ингэж малын зүй бүс хорогдлыг багасгах төл бүрийг мал болгох ажилд эвлэлийн гишүүн бүр манлайллаа өндөрт өргөн бүх ард түмний социалист уралдааны хоёр дахь жилд урьд оныхоос улам их амжилт гаргахаар шамдаж ажиллаж байна.

Г. БЯМБАРИНЧИН

МАЛЧДЫН НӨР ХӨДӨЛМӨРИЙН ҮР ДҮН

Ходоо орон нутагт мал төлөлтийн ажил ихэвчлэн төл бүрэл сайн бойжиж байгаад малчид, төлчид урамтай байна. Энэ талаар сурвалжлагч идэвхтэн Д. Отгон, Ш. Гантомор, Л. Хончиахан, Г. Лувсанням нарын ирүүлсэн мэдээг нийтлэв.

Саяхны байдлаар Эрдэнэ сумын «Туяа» нэгдлийн «Нарстай» бригадын хэмжээгээр нийт төлөх хонины 67 хувь нь төлөж гарсан төл нь 102 хувийн бойжилттой байна.

Дэндү сумын үзүүр, Дэндү сумын Буурлын цогцол төлөө бүр хаана л хонь хөдөө бүр байгаа бол төлийн дуун цагид бол уулзсан малчид «Төл мэнд» гэцгээн утгана. Намын гишүүн Саарай, Чойнын хурга, илгээлтийн эзэн, Гадамсүрэн 207 хониноос 207 хурга, нийслэлээс ирсэн төлчин Д. Бүүвэй (VI конторын) 130 хониноос 130 хурга, Сэнгээ (Улсын их дэлгүүрийн) 115 хониноос 115 хурга бойжуулж байна.

Бүрэн сумын «Бүрэн-

дэлгэрэх» нэгдлийн «Баян-цогт» бригад өнгөрсөн гурван жилийн дунджаас зүй бүсын хорогдлыг 53 хувиар, том малын хорогдлыг 592, төлийг 526, эх малын хээл хаялт, суваргалтыг 759 малаар тус тус багасган 1974 онд 36,3 мянган малтай болох зорилттой байна.

Энэ бригадын 9,3 мянга гаруй хонь, ямаа, 100 гаруй гүү, 180 гаруй үнээ төлөж хоньчин Мандалсүрэн, Ц. Ширчин, Дэмбэрэлдорж, Дамба, Мөнх нарын суурь нэгч төлийн хорогдолгүй, тус бүр 7-13 ихэр төл илүү бойжуулж байна.

Алтанбулаг сумын «Ногоо» бригадын ухуулагч АХШГ-ийн гишүүн Жагварал ахлагчтай за-

луучуудын шалган сурталчлах морин аялалынхан сумынхаа «Алтан-Овоо», «Жаргалант» бригадын сууриудад явж МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 340,51 дүгээр тогтоол, малын зүй бүсын хорогдлыг багасгах талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол, төл бойжуулах арга технологийг үзүүлэн тэйгээр таниулж тэргүүний малчин Самбуу, Дашням нарын туршлагыг судлууллаа.

Тэд 300 гаруй км газар мориор аялаж 31 суурийн 200 гаруй хүнд яриа таниулга хийсний гадна 10 шахам мянган төлийн бойжилтыг үзэж 3 суурийн төл бойжилтыг шалгав.

Сэргэлэн сумын «Авдархангай» нэгдлийн «Авдар» бригадын Ж. Чогдонгийн хониноос 3 ихэр хурга гараад мэнд бойжиж байна.



Бүрэн сумын «Бүрэндэлгэрэх» нэгдлийн «Хайрхан» бригадын хоньчин МАХН-ын гишүүн Б. Пагваанайдаг 500 гаруй төлөх мал хариуцан маллаж одоо 92 хувь нь төлөөд гарсан төлийн нь хорогдолгүй бойжуулж байна.

ЗУРАГ ДЭЭР:

МАХН-ын гишүүн, хоньчин Пагваанайдаг

С. ЦЭДЭВ-ийн авсан гэрэл зураг

Мэргэжилтний зөвлөлгөө

ХУРГАНЫ ТЭЖЭЭЛЛЭГ

Хургыг зөв тэжээж бойжуулан зохих чиглэлийн өндөр ашиг шимт хонь болгоход тэжээллэг ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Эхээс төрсний дараах 3-4 хоногт хурга эхийнхээ сүүгээр тэжээгдэх тул хурганы өсөлт хөгжилт, эрүүл мэндийн байдал эхийнхээ сүүний хэмжээ чанараас шууд хамаарна. Хөхүүл хурга эхийнхээ сүүний уургийг 75-80 хувь шингээн ашиглаж чаддаг.

Иймд хурганы сүүн тэжээлгүйг аль болох хангалттай явуулах нь чухал юм.

Хургыг 3-4 долоо хоногтойгоос эхлэн хивэг зэрэг хүчит тэжээлээр тэжээх хэрэгтэй.

Хурганд өгөх энэ хүчинт тэжээлийн хэмжээ эм ховинны саам, сүүний чанараас болж нээ бүр байж болно.

Хүчит тэжээлийг хур-

ганд эхлээд өдөрт 10-20 грамм хүртэл үржлийн хурганд 300-400 грамм өгнө. Хурганд ногоон үед нь хадаж бэлтгэсэн өвс тохиромжтой байдаг.

Хурганд эрдэс бодис дутагдсан шинж гарвал нэг хурганд 5-10 грамм нүүрс хүчлийн кальц ноогдохоор бодож тэжээх хэрэгтэй.

Хурганд Р ба Д витамин шаардагдана.

Нэг нас хүртлэх хурганд 100 кг амьдын жинд 12-15 кг каротин (А витамин) ноогдохоор тэжээнэ.

Тэжээлгүйг ингэж тохируулан явуулбал хөхүүл хурганы жин хоногт 200-300 граммаар нэмэгдэнэ.

Хургыг 3-4,5 сартайд нь эхээс салгана.

Хэрэв эхийг саадаг бол сайн үүлдрийн хургыг 2,5-3 сартайд нь салгана. Эхээс салгасан үед

тэжээллэг маллагааг сайн тохируулбал хурга хурдан өсч бойжин хоногт 160-200 грамм нэмэгдэл жинтэй болно.

Эхээс салгасан хургыг суурилан хувааж чанар сайтай бэлчээрт маллах хэрэгтэй.

Бэлчээрийн ургац сайн бол хурга ямар ч нэмэгдэл тэжээлгүйгээр маш сайн өсөн торниж чадна.

Харин өсөлтийн нь бүрэн гүйцэт сайн болгохын тулд өдөрт 200-250 грамм хүчит тэжээлээр нэмж тэжээх нь чухал.

Хүчит тэжээлийн нэмэгдлийн үржлийн охин хурганд 400 грамм, эр хурганд 600 грамм хүртэл өгч болно.

Хурганд хошуу будаа, эрдэнэ-шиш, арвай зэргийг хивэгтэй хольж өгнө.

Хургыг эхээс салгасны дараа тэжээллэг дутснаас болж цээжний урт гүн нь хөгжиж чадаагүй учир хурга урт хөлтэй нарийнхан биетэй булчин мах нь сул хөгжсөн амьдын жин багатай хонь болно.

П.БАЯРХҮҮ

ИДЭВХТНИЙ МЭДЭЭ

Лүн сумын «Энх туул» нэгдлийн «Өгөөмөр» бригадын хоньчин Цэрэндорж, Лхагваа, Жамбал, Найдан нарын суурь нэгдүгээр самналтаар 49-96 кг ноолуур авчээ.

«Энх» бригадын Ёндонжунай ахлагчтай СХ-ийн хэсгийн үхэрчин Балжинням, Сампил, Хишигт нар 100-180 үхэр хөөвөрлөж 56-93 кг хөөвөр аваад бусдыгаа хошуучилж явна.

Тус сумын ХЗЭ-ийн гишүүд залуу малчид хөдөлмөр соёлын 10 сарын аяндаа эмнэг хангал сургаж, илгээлтийн эзэн адуучин Балжинням 54 морь, Гунгаасэд, Рэнцэнхорлоо нар 33-39 морь, 3-4 тэмээ уналга эдэлгээнд сургаж бусдыгаа хошуучиллаа.

Д.ХИШИГДОЛГОР
Г.ТЭГШЭЭ



Москвагийн хөгжим бүжгийн дунд сургууль 200 жилийн түүхтэй юм.

Энэ сургууль бүжгийн урлагийн олон ангистнууд торон гарсан юм.

Зураг дээр: Бүжгийн сургууль хийж байгаа нь.

ТАСС-ын гэрэл зураг

БОЛСОН ЯВДАЛ

ГАЛЫН ДУНДААС

Саяхны нэг өдөр Зуунмод хотын 1 дүгээр хорооны иргэн Г-гийн цоожтой гэрийн тооноор мушгиралдсан хар утаа гарч байхыг Зуунмод хотын 1 дүгээр хорооны 64 настай өвгөн Түвдэн, 60 настай эмгэн Доржпалам нар харж, гал гарч байгаа айл дээр сандран гүйж иржээ. Цоожтой гэрийг Түвдэн, Доржпалам нарыг онгойлгоход гал дүрэлзэж гэг-

рээр дүүрэн гашуун хар утаа манарч юу ч харагдахгүй зөвхөн хүүхдийн уйлах дуу л сонсогдоно.

Энэ буурлууд төрхөн агшинд гэрийн хаалгыг цөм цохин орж шатаж байгаа гэр дотроос ах дүү хоёр хүүхдийг гаргаж амийн нь аврав.

Бяцхан иргэдийн амийг аварсан энэхүү ачтан өндөр настан Түвдэн, Доржпалам нартаа хоёр хүүхдийн эцэг эх, хөдөлмөрчид гүн талархлаа дэвшүүлж байна.

Д.СУРАХБАЯР

Сонинд ирсэн захидал

ХЭЗЭЭ ГЭРЭЛТЭЙ БОЛОХ БОЛ...

Эрдэнэсат сумын дунд сургуулийн дотуур байрны эрэгтэйчүүдийн тасаг цахилгаан гэрлээр байнга дутагдаж байна.

Манай байшингийн хоёр талаар явсан гэрлийн угсанд 10 метр утас залгавал энэ байр гэрэлтэх юм.

Энэ байшинд айл сууж сайхан гэрэл гэгээтэй байгаа атал 9 дүгээр сард байр нээгдсэнээс хойш лаагаар гэрэл хийж ирэв.

Энэ нь хичээл давтахад бэрхтэй юм.

Чухамдаа сумын төвд биднийхээс өөр гэрэл ца-

хилгаангүй барилга орон сууц ер алга.

Гэрэл дутагдалтай байгаа энэ байдлыг сумын удирдлагууд, багш нар, цахилгаан станцын мэргэжилтнүүд мэддэг л байх, хэзээ гэрлээр хангаж өгөх бол гэж харсаар бараг жил өнгөрлөө.

Одоо бидний анги дэвших шалгалт болж байгаа үед гэрэл улам чухал хэрэгтэй болоод байгааг аймгийн сониноор дамжуулан дээрх нөхдийн сонорт хүргэе.

Суратч Б.ЖАМБАЛ

ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛҮҮЛЭВ

Сумынхаа ХБА-ийн 1 дүгээр улирлын төлөвлөгөөг биелүүлэхэд туслалцаж Лүн сумын ХЗЭ-ийн үүр ном борлуулж төлөвлөгөөг 103,3 хувиар,

нохойн арьсыг 125,7 хувиар, 8 жилийн дунд сургууль ясны 60 шахам хувийг биелүүлэв.

Ш. БАДАМ

ТАРИАЛАНГИЙН ШИНЭ ТЕХНИК

Газар бол дуусашгүй эх булаг. Иймээс хөрсний байнгын үржил шимтэй байлгах, салхины эд-рүүлээс хамгаалахад зориулагдсан ажлын бүтээл өндөртэй шинэ техникүүд газар тариаланд хэрэглэгдэж байна. Үүнд:

1. КПГ-50 гүн хавагч анжисыг ДТ-54, Т-74, ДТ-75 тракторт агрегатлан 20-нос 30 см-ын гүнд хөрснийг эргүүлэхгүйгээр хавж хагална.

Хагалсны дараа талбайн гадаргууд 80 хувь гуурс үлдэнэ.

Чиргүүлийн ПН-5-35 гэдэг анжиснаас 2,5 дахин хөнгөн, бүтээл нь 1,4-1,7 дахинх, уг анжисыг ДТ-75 тракторт агрегатлан ажиллуулахад цагт 0,8 га, ажлын 8 цагт 6,4 га газрыг боловсруулна.

КПП-2,2 хаван сийрүүлэгчийг ЗХУ-ын Алтайн ХАА-н машины заводад үйлдвэрлэдэг.

Энэ нь ямар ч тракторт агрегатаж болохоос гадна, СП-15 холбооны тусламжтайгаар 2-3 сийрүүлэгчийг 3 тонын даацтай тракторт, 3-5 сийрүүлэгчийг 5 тонын даацтай тракторуудад холбож 8-15 см гүнд боловсруулалт хийхэд талбайн гадаргууд 80-90 хувийн гуурс байдаг.

Энэ машин паранд тарианы өмнөх боловсруулалтыг дэс дараатай хийхэд зориулагдсан юм.

3 тонын даацтай тракторын агрегат нь цагт 3,2 га-д боловсруулалт хийж чадна.

БИГ-3 шивүүр борной

хамрах өргөн нь 3 метр, олон наст ургамал, зэрлэгийг устгах, хөрсний чийгийг хаах үүрэгтэй.

Явж байх үед борнойны шүд өөрөө ирлэгддэг сайн талтай.

Явалтын өнцгийг гурван байдалд тавьж тохируулдаг.

Үүнийг хэдий хэмжэний өнцөгтэйгээр талбайд явуулахыг агрономчшид-вэрлэнэ.

ДТ-75-ын цогцолбор цагт 7,75 га-гийн ажил гүйцэтгэнэ.

Гуурсанд таригч СЗС-2,1 үрлэгч бол тарианы өмнөх сийрүүлэлт хийж, гуурстай талбайд үр тариаг эгнүүлэн суулгах, бордох, булдах ажлыг зэрэг гүйцэтгэнэ.

Мөн тарьж байгаа үр ямагт хөрсний чийгтэй хэсэгт сууж соёлолт зэрэг жигд түргэн байдаг.

Үрлэгч дээр хүн байх шаардлагагүй талбайн гадаргууд далан бий болгодог учир хөрснийг салхины элэгдлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлж өвөлжих улаан буудайг тариалах бололцоог сайн хангадаг. Дугуйт тракторт 1 үрлэгчийг СЗР-02000 маркын холбооны тусламжтайгаар, ДТ-75 тракторт 3-ыг агрегатлан цагт 2,5 га-д үрлэгээ хийх нормтой юм.

Ц. МАЖИГСҮРЭН

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

ЗАРЛАЛ

Батсүмбэр сумын харьяат Лхамаа овогтой Алтанхүү нь эхийн тэтгэврийн 76372 номерын дэвтрээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцон.

Д.ТОВУ